

# **Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтыг шинэчлэн батлах тухай /2004-05-03/**

## **МОНГОЛ УЛСЫН НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙДЫН ТУШААЛ**

2004 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Улаанбаатар хот

### **Дугаар 77**

Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтыг шинэчлэн батлах тухай

Даатгуулагч иргэдээс удаа дараа ирүүлж буй өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, Улсын мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн нөхцлийн шинжилгээ, судалгааны төвийн хэмжилт, судалгааны дүн, Засгийн газрын 1995 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийг үндэслэн **ТУШААХ**

**НЬ:**

1. "Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт "-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэхүү жагсаалтыг баримтлан тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоож байхыг Улсын нийгмийн даатгалын ерөнхий газарт зөвшөөрсүгэй.
3. Хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа ажилтны ажил мэргэжлийн нэрийг уг жагсаалттай нийцүүлэн нийгмийн даатгалын дэвтэрт тодорхой бичиж байхыг аж ахуйн нэгж, байгууллагад даалгасугай.
4. Хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа болон ажиллаж байсан ажилтны нийгмийн даатгалын дэвтэрт бичигдсэн ажил мэргэжлийн нэр ажил олгогчийн буруугаас энэхүү жагсаалттай зөрчилдсөний улмаас тэтгэвэр тогтоолгох асуудлаас гарч буй гомдол маргааныг "Ажил олгогч, даатгуулагч болон Нийгмийн даатгалын байгууллагын хооронд гарсан саналын зөрөөг хянан шийдвэрлэх гомдлын шаардлагын зөвлөл"-өөр хэлэлцэн шийдвэрлэж байхыг Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудад үүрэг болгосугай.
5. Энэ тушаал гарсантай холбогдуулан Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайдын 1995 оны 78, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1999 оны А/264 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД**

**Ши.БАТБАЯР**

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын  
2004 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн  
77 дугаар тушаалын хавсралт

**ТЭТГЭВРИЙГ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ТОГТООХ ГАЗРЫН ДОР БОЛОН ХӨДӨЛМӨРИЙН ХОРТОЙ,  
ХАЛУУН, ХҮНД НӨХЦӨЛД ХАМААРАХ АЖИЛ МЭРГЭЖЛИЙН**

## ЖАГСААЛТ

### Нэг. Газрын доорх уурхайн ажил мэргэжил:

1. Тоног төхөөрөмжийн машинч
2. Гүний бэхэлгээчин
3. Тэсэлгээчин
4. Уулын ажилчин
5. Тэсрэх материал зөөгч
6. Угсрагч
7. Маркшейдерийн ажилчин
8. Хий хэмжигч
9. Сорьц авагч /геологийн ба уулын үйлдвэрийн/
10. Дохиочин
11. Орлуулагч /уурхайн бэхэлгээний материал/
12. Насосны машинч
13. Цахилгаан тэрэгний машинч, түүний туслах
14. Цахилгаанчин
15. Тоног төхөөрөмжийн слесарь
16. Цахилгааны слесарь /газрын дор ажилладаг цахилгаанчин/
17. Компрессорчин
18. Газрын дор эмнэлгийн байртай аваарын эмч

19. Цооног өрөмдөгч

20. Гагнуурчин хийн огтлогч

21. Газрын дор ажлын өдрийн туршид ажилладаг үндсэн ба бэлтгэл малталт, ашиглалт, агааржуулалт, тээвэр, засвар, монтаж-өрөмдлөг, чигжилт, уулын сэргээлтийн хэсгийн туслах ажилчин, ээлжийн мастер, инженер, засварчин, хөдөлмөр хамгааллын инженер, гүний уурхайн цехийн дарга, хэсгийн техникийн удирдагч, хэсгийн механикч, геологич, маркшейдер, технологич.

22. Уулын цэрэгжүүлсэн аврах ангийн байлдагч, уулын цэрэгжүүлсэн аврах ангийн дарга.

### **Хоёр. Хөдөлмөрийн хортой нөхцөл**

**1.** Цацраг идэвхит бодис агуулсан хүдэр, ашигт малтмал зөөдөг илчит тэрэгний жинхэнэ, туслах машинч, холбогч, найруулагч, пүүлэгч, зам засагч, вагон, машин механизм, нисэх онгоцны эд ангийг бензин, керосин, солярк, хүчил, шүлт зэрэг хортой уусмалд цэвэрлэж засдаг засварчид, шүүлт угаагч-техникч, аккумулятор цэнэглэгч, аккумулятор цутгагч, засварчин, батерейн гагнуурчин, цехийн дарга, резин хуванцар шахагч, технологич, мастер, үе угсрах, металл өнгөлөгч, инженер химич, авто засвар, үйлдвэрлэлийн резинэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх суурь машинч, резинэн дугуй нөхөх суурь машинч, резинэн цавуу бэлтгэгч, үе угсрах баазын замчин, техникч, мастер, бригадын дарга, үе задлах, угсрах машины операторч, сумт ба гүүрэн кранчин, туслагч, оосорлогч, модонд үл ялзруулах бэхжүүлэх бодис түрхэгч, мастер, сэргээн засварлах цехийн операторчин, мастер, дэр модонд химийн бодисоор нэвчрүүлэлт хийдэг үйлдвэрийн мод нэвчүүлэн идээлэгч, оосорлогч, лаборант, технологич, үе угсрах баазын мастер механикч, соронзон орны үйлчлэлээр төмөр замын хос дугуйн далд гэмтлийг шалгагч, вагон будагч.

**2.** Цемент үйлдвэрлэлийн тоосны камер цэвэрлэгч, цемент савлагч, түүний туслах, цемент шахах насосны машинч, бултуур, зуух, тээрэм, туузан дамжлагын үйлчлэгч (операторч).

**3.** Керамик эдлэл үйлдвэрлэлийн тоосруулан хатаах зуухны операторч, туузан дамжлагын операторч, хавтан шатаах зуухны машинч, тоног төхөөрөмжийн засварчин, шатаах зуухны цахилгаанчин, фритт бэлтгэгч.

**4.** Карьерийн аж ахуйн уулын цехийн өрөмдөгч, бултуурын машинч, өрмийн машинч, түүний туслах, туузан дамжлагын операторч, шигшүүрийн машинч.

**5.** Байшин үйлдвэрлэлийн хийн зүсэгч, хольц бэлтгэгч, тоног төхөөрөмжийн засварчин, түүхий эд бэлтгэлийн хуурай материал бэлтгэгч, татагч, засварчин.

**6.** Барилгын бетон үйлдвэрлэлийн бункерийн машинч, химийн хольц бэлтгэгч, конвейерийн машинч, асфальт бэлтгэгч, тос найруулагч, барилгын шаварчин, будагчин (засал чимэглэлч), зуурмагийн цехийн мастер, цехийн дарга.

**7.** Мебель үйлдвэрлэлийн гуалин чанагч, хуулга наагч, цавуу зуурагч, лак будгаар өнгөлөгч, цавуу түрхэгч, хавтан наах суурь машинч, лак будгийн мастер.

**8.** Зоос, гоёлын зүйлийн үйлдвэрлэлийн механик ба химийн аргаар металл өнгөлөгч, металл хучигч, тэмдэг (одон медаль) гоёлын зүйлийг пааландагч, үнэт чулуун эдлэл хийгч, ган сийлбэрчин, цутгуурчин.

**9.** Арьс шир, үслэг эдлэлийн үйлдвэрлэлийн химийн боловсруулалтын цехийн мастер, арьс дэвтээгч, намаз түрхэгч, үс авагч, арьс шохойдогч, гандагч, шохой зуурагч, шохойн шим намаз бэлтгэгч, арьс махлагч, годлогч, тайрагч, бүх төрөл бүрийн уусмалаар арьс угаагч, шахагч, сунгагч, арьс идээлэгч, хусагч, арьс будагч, үслэг арьсыг органик уусмалаар угаагч, самнагч, элдэгч, шуудуу цэвэрлэгч, гүүрэн кранч, хими цэвэрлэгээний машинч, химийн уусмал найруулагч, уусмал түрхэгч, өнгө будагч, эмульс лак шүршигч, шүрших машины операторчин, будаг найруулагч, хүхэрт натри хайлагч, индүү машин баригч, ногоон арьс ялгагч, шохой арилгах, зөөлрүүлэх дамжлагын ажилчин, химийн материал бэлтгэгч, ачиж буулгагч, резинэн цавуугаар лент, цаваг наагч, нойтон арьс давслагч, бункерийн цэвэрлэгч, химийн материалын

нярав, туршилтын цехийн туршигч.

**10.** Гутлын үйлдвэрлэлийн болон резинэн ба халиман цавууны цехийн мастер, цавууны цехийн мастер, цавуу найруулагч, цавууны суурь машины засварчин, резинэн хольц бэлтгэгч, хольц бэлтгэгч суурь машинч, трихлоризоцианы хүчлээр уусмал бэлтгэгч, ул наагч, гутлын будаг найруулагч, хлорпрен, полуратан суурьтай болон резинэн цавуугаар цавуудагч, халиман цавуу чанагч, шүүгч, угаагч, үрэлжүүлэгч, хатаагч, савлагч, компрессорчин, түүхий эд бэлтгэгч, хэрчигч, лаборант, өнгө будаг шүүригч, мастер.

**11.** Цахилгаан химийн цаасаар цаг агаарын мэдээлэл авч боловсруулалт хийдэг синоптик инженер, операторч, хиймэл дагуулын станцын инженер.

**12.** Мөнгөн устай багаж шулуутгагч, ил задгай мөнгөн устай хэмжүүрийг засах, цэнэглэх ажил дээр ажлын өдрийн туршид ажилладаг инженер, техникч, слесарь, мастер, пложриграфчин.

**13.** Малын боом, бруцеллёз, галзуу, сүрьеэ, ям зэрэг өвчний вакцин, вирус, ийлдэс, гаммоглобулин, антибиотик, онош зүй, утил бэлтгэн савлах, хатаах, омог хайрцаглах, вивар, химийн цехийн их, бага эмч, технологич, химич, микробиологич, ахлах бага эмч, лаборант, бага эмч, ферментч, био бэлдмэлийн ариутгагч, бэлдмэл савлагч, машинч, бутлагч, аппаратчин, Дукийн жолооч, хорио цээрийн санитарч, найруулагч, хатаах машинч, жигдрүүлэгч, компрессорчин, засварын слесарь, хөлдөөх, хатаах төхөөрөмжийн техникч, хорт хий зайлуулах төхөөрөмжийн жижүүр, сантехникийн слесарь, гагнуурчин, бохирын слесарь, малын эм бэлдмэл шалгах лабораторийн малын их, бага эмч, биобэлдмэлчин, ариутгагч, лаборант, химич.

**14.** Нефть боловсруулах үйлдвэр КИПА засварчин, лаборант, механик, гагнуурчин, сантехникийн засварчин, бензин, нефть зэрэг хортой шингэний резервуарын дотрыг уураар утан цэвэрлэх, засварлах ажил хийдэг резервуар цэвэрлэгч, тоног төхөөрөмж, шугам хоолойн засварчин, цистерн, банк, резервуар, худаг дотор цахилгаан хийн гагнуур хийдэг гагнуурчин, насосчин, нефть хангамжийн операторчин, тос шингэн савлагч, торх угаагч, ачаа шалгагч, лаборант, шил сав угаагч, шатахуун ачигч, буулгагч, нярав, цэнэглэх машины жолооч, тос цэвэрлэх цехийн ажилласан тос дахин боловсруулах үйлдвэрийн тос нэрэгч, тунгаагч, мастер инженер

**15.** Цацраг идэвхит эх үүсвэр (альфа, ветта, гамма цацраг, рентген туяа, ионжуулагч цацрагаар)-ээр оношлогоо, эмчилгээ, шинжилгээ гардан хийдэг их, бага эмч, сувилагч, асрагч, инженер техникч, лаборант, эрдэм шинжилгээний жинхэнэ, туслах ажилчин.

**16.** Байгалийн голомтот халдварт өвчнийг эсэргүүцэн судлах төвийн нян судлалын их эмч (бактериологич), клиникийн их эмч (гоц халдвартын), пато-анатомич (гоцын), вирус судлагч, халдвар судлалын их эмч, хор судлагч, амьтан судлагч, шимэгч судлагч, нянгийн био химич, тэжээлийн био химич, нянгийн генетикч, амьтны генетикч, шимэгч судлалын лаборант, амьтан судлалын лаборант, халдвар судлалын бага эмч, ариутгагч, бэлдмэлчин, шил сав угаагч, бактериологийн лаборант.

**17.** Халдваргүйтлийн ахуйн хортон, шавьж, мэрэгч устгах хорт бодис найруулан бэлтгэх, шинжлэх, судлах, сорилт, туршилт хийх, ачих буулгах, тээвэрлэх, хадгалах ажил эрхэлдэг ажилчин, хор өгөш бэлтгэгч, ариутгагч, химич.

**18.** Цөмийн изотол, цацраг туяа, рентген фотоэмульс спектрийн шинжилгээ гардан хийдэг физик химийн лабораторийн эрдэм шинжилгээний тэргүүлэх, жинхэнэ, туслах ажилтан, физикч инженер, химич, биохимич, эрдэс чулуу судлагч, техникч, лаборант, бэлтгэгч, шил сав угаагч, мөнгөн усны барометрийн инженер, хийн генераторчин, тоног төхөөрөмжийн засварчин, тун хэмжигч.

**19.** Олон нэр төрлийн химийн бодисыг ашиглан өргөн хүрээтэй шинжилгээ судалгаа хийдэг эрдэм шинжилгээний тэргүүлэх, ахлах, жинхэнэ, дэд, туслах ажилтан, лаборант, геологи шинжилгээний гүйцэтгэгч инженер, металлургын инженер, өнгөлгөөний мастер, өнгөлөгч, гүйцэтгэгч лаборант, шил сав угаагч, препаратторч.

**20.** Ацетилины үйлдвэрлэлийн генераторчин, компрессорчин, аппаратчин, засварчин, цэнэглэгч, цахилгаанчин.

**21.** Кино үйлдвэрлэлийн зургийн хор найруулагч, зураг угаагч, ультра дуугаар дефект цэвэрлэгч, хор плёнкны чанар тодорхойлогч, хими- технологийн инженер, ээлжийн болон химийн инженер, лаборант, негатив, монтажчин.

**22.** Хэвлэлийн үйлдвэрлэлийн бар цутгагч (тугалга хайлагч), өндөр офсет хэвлэлийн хэвлэгч, гараар үсэг өрөгч, боогч, лентоп машинч, алт дарагч, фото зургийн лаборант.

23. Цахилгаан шүүлтүүрийн үнс зайлуулах төхөөрөмжийн ээлжийн слесарь, монтёр, үнсчин, засварчин, тунгаасан усны насосны станцын машинч, химийн уусмал найруулагч.
24. Батлан хамгаалахын цэргийн зориулалттай буу, дуран, гэрэлтүүлдэг багажны засварчин, буунд тусгал оруулдаг засварчин, аккумулятор хийгч, Батлан хамгаалахын химийн албаны цехийн дарга, засварчин жолооч, химийн бодисын нярав, засварын механикч, инженер, дозиметрийн багаж тохируулагч, дозиметрчин.
25. АН-26, АН-24, БОИНГ-13-727, АН-2, МИ-8, Ю-12, А-310, АН-30 онгоцны нисэх багийн дарга, хоёрдугаар нисгэгч, хөлгийн инженер, механикч, холбоочин, нисэхийн хянагч, үйлчлэгч, онгоцонд засвар үйлчилгээ хийдэг инженер, техникч, цахилгаан хийн гагнуурчин, лакаторын засварчин, аккумуляторын будагчин.
26. Гал унтраах ажиллагаанд оролцдог жижүүрийн албаны гал сөнөөгч, жолооч, гал унтраах ажлын удирдагч, хэрэг бүртгэгч, галын хор цэнэглэгч.
27. Уул уурхайн баяжуулах фабрикийн конвейерийн машинч, бутлах тээрмийн машинч, урвалж найруулагч, урвалж уусгагч, ачигч, тоног төхөөрөмжийн ба цахилгааны жижүүрийн слесарь, гүүрэн кранчин, хэсгийн дарга, мастер, ахлах мастер, хэсгийн механикч, цахилгаанчин, гагнуурчин, нитро будаг найруулагч, тугалга хайлагч, тугалган гагнуурчин, марганцат ганг хийгээр зүсэгч, металл эдлэлийг резинээр хуяглагч, зэс ялгах үйлдвэрийн инженер, механикч, химич-инженер, лаборант, химийн материалын нярав, ээлжийн ахлагч, операторчин, засварчин, цахилгаанчин, сантехникийн слесарь, туслах ажилтан, тэсрэх материалын цехийн мастер, тоног төхөөрөмжийн засварчин, тэсэлгээчин, операторч.
28. Шүдэнзний үйлдвэрийн толгойн бодис найруулагч.

### **Гурав. Хөдөлмөрийн халуун нөхцөл**

1. Эрчим хүч үйлдвэрлэлийн 35 ата ба түүнээс дээш даралтаар ажилладаг зуухны машинч, ахлах машинч, шугам хоолой, арматур, халах гадаргуугийн слесарь, зуухны цехийн ба тос бэлтгэх тоноглолын засварчин, өрлөг дулаан тусгаарлалтын засварчин, туслах тоноглолын машинч эргүүлч, зуухны ээлжийн мастер, засварын инженер, ашиглалт, засварын мастер, мастер, зуухны цахилгаан ба хийн гагнуурчин, зуух үлээлгэгч, шаар цэвэрлэгч.
2. Металл төмөр боловсруулах үйлдвэрлэлийн ширэм, металл хайлагч, хайлагч оператор, мастер, цех хэсгийн дарга, хайлуулах зуухчин, хэвчин, цутгуурчин, бэлтгэгч, халуун төмөрчин, лантуучин, мастер, гүүрэн кранчин, операторч, элс хатаагч, зуух доторлогч, индукцын зуухны хайлагч-цутгамал цэвэрлэгч, оосорлогч, цутгамал сугалагч, металл цувигч, зуухчин, металл тэгшлэгч, таслагч, баяжмал хатаагч, металл цувигч, металл хучигч, ширэм өнгөлөгч, нуман зуухны хайлуулах операторч, засварчин, цахилгаанчин, цутгах цехийн шанага, бэлдэц цутгах, хайчны операторч, ахлах операторч, шанага доторлогч, бэлдэц дахин халаах зуухны операторч, бэлдцийг хийн гагнуураар тайрагч, засварын болон төгсгөлийн цувих тоноглолын операторч, цувимал бүтээгдэхүүн боогч, оосорлогч, хайчлагч, хөргөх, шалгах тавцангийн операторчид, цувимал бүтээгдэхүүн тоологч, шингэн металл зөөгч, краны машинч, хаягдал төмөр холигч.
3. Цементийн үйлдвэрлэлийн эргэх зуухны жинхэнэ, туслах машинист, зуух тослогч, доторлогч, ределерийн үйлчлэгч.
4. Тоосгоны үйлдвэрлэлийн тоосго шатаах зуухны галч, зуухны суваг цэвэрлэгч, тоосго өрөгч, гаргагч, үнс нурам цэвэрлэгч, нүүрс оруулагч, зуухны ам нээж, хаагч, зуухны засварчин, покарийн жолооч.
5. Эрдэс хөвөнгийн үйлдвэрлэлийн вагранк зуухны машинч, хөвөн үүсгэгч төхөөрөмжийн операторч.
6. Арьс шир, үслэг эдлэлийн үйлдвэрлэлийн гинжит ба раман хатаалгын хатаагч.

### **Дөрөв. Хөдөлмөрийн хүнд нөхцөл**

1. Эрчим хүч үйлдвэрлэлийн дулааны шугам хоолойн слесарь, дулааны оруулгын слесарь, сүлжээний насосны ээлжийн машинч, сантехник, дулаацуулга, салхилуурын засварчин, электролизийн төхөөрөмжийн цахилгаан монтёр, гал унтраах цацраг идэвхт мэдээлэгчийн монтёр, хөөсөөр гал унтраах төхөөрөмжийн цахилгаан монтёр, түлш дамжуулах тоноглолын засварын слесарь, машинч, цехүүдийн тоноглолын засварын слесарь, цахилгаан машин, трансформаторын засвар ороомог хийх монтёр, реле хамгаалалт автоматикийн монтёр, өндөр

хүчдлийн оруулгын засварын монтёр, цахилгаан хэмжүүр, автоматик туршилт хэмжилтын монтёр, дулааны хянах хэмжүүр автоматикийн засварын слесарь, 6 киловатын өндөр хүчдлийн цахилгаанчин, нэгж агрегат нь 120 квт-аас дээш хүчин чадалтай суурин дизелийн цахилгаан станцын дизелийн ахлах машинч, машинч, суурин дизелийн цахилгаан станцын туслах тоноглолын машинч-эргүүл, дизель хөдөлгүүр, түүний туслах тоноглолын засварын слесарь, дизелийн цахилгаан станцын удирдах щитийн цахилгааны монтёр, жижүүрийн цахилгаан монтёр, трубины цехийн засварчин, мастер, өнгөлгөөчин, багаж ирлэгч, халуун төмөрчин, цахилгаан ба хийн гагнуурчин, компрессорчин, аккумулятор цэнэглэгч, бохирын слесарь, металл хучигч, (гальванк), мазут тоноглолын машинч, конденсат, эргэлтийн усны насосны машинч, түлш буулгах төхөөрөмжийн машинч, түлш дамжуулахын удирдах щитийн машинч, түлш дамжуулахын машинч, хатаагч, гэсгээгчийн машинч, турбин цехийн ахлах машинч, турбины машинч, турбины туслах тоноглолын машинч-эргүүл, тэжээлийн насосны машинч, бойлерийн машинч, дээраторын машинч, жижүүрийн слесарь, удирдах ерөнхий щитийн цахилгаан монтёр, жижүүрийн цахилгаан монтёр, жижүүрийн ахлах монтёр, тоног төхөөрөмжийн гадаргууг цэвэрлэгч, механикжсан цэвэрлэгээний машины дулаан хянах хэмжүүрийн автоматикийн цахилгааны слесарь, эрдэс хөвөнгөөр дулааны шугам дулаалагч, шугам дулаалагч, байнгын ажиллагаатай уурын зуухны галч, цахилгаан хөдөлгүүрийг байнга задалж, засаж угсрагч, ороомог, хөндийрүүлэгч, мотор ороогч, хөдөлгүүрийн цахилгааны ширэм хийгч, эрчим хүчний үйлдвэрийн муфт үйлдвэрлэлийн монтёр, мастер, түлш дамжуулах цехийн дамжлага, вагон хөмрөгч, туузан тэжээгч, бутлах төхөөрөмжийн машинч, туслах машинч, засварчин, мастер, зуухан цехийн горимын машинч, вагерын машинч, тоног төхөөрөмжийн засварчин, тээврийн машинч, тоосны системийн машинч, утаа сорогчийн машинч, устөрөгчийн тоноглолын засварчин, (кабель, шугам засварын монтёр), тос сэргээх байгууламжийн тоноглолын слесарь, хамгаалалт, хими, даралт, зарцуулалтын хэсгийн засварчин, засвар, механикийн цехийн мастер, агаар задлах аппаратчин, лаборант, химийн ус цэвэрлэгээний машинч, сантехникийн ээлжийн засварчин, ариутгах татуургын засварчин, цахилгаан тоноглолын засварчин, түлш дамжуулахын нүүрс түрдэг тракторчин, замчин, кранчин, хөдлөх зөөх, өргөх механизмын засварчин, барилгын засварчин, циклон, сепараторын засварчин, холбооны монтёр, дэд станцын ашиглалтын мастер, агаар задлах, ариутгах төхөөрөмжийн мастер, үнс нурам зөөгч, ээлжийн ба засварын монтёр, түлш зуух, турбин, цахилгаан хими цехүүдийн ашиглалтын инженер, цехийн дарга, станцын ээлжийн инженер, хөдөлмөр хамгааллын инженер, техник хяналтын инженер, дулааны хянах хэмжүүр автоматикийн цехийн болон ээлжийн дарга, автоматикийн инженер, мастер, засвар, хаалт хамгаалалт, дохиолол хамгаалалт, ашиглалт, хэмжүүрийн инженер, цахилгаан техникч, засварчин, цахилгаан цехийн цахилгаан лабораторийн эрхлэгч, ээлжийн дарга, реле хамгаалалт, автоматик, хөдөлгүүр засвар, теле механик, холбоо, кабель засвар, хуваарилах байгууламж, трансформатар, нарийн хэмжүүр, хэмжилт, туршилт хамгаалалтын инженерүүд, зуухан цехийн горимын инженер, техникч, ээлжийн дарга, турбин цехийн засварын инженер, ээлжийн дарга мастер, халах гадаргуугийн засварчин, үйлдвэрийн цэвэрлэгээ үйлчилгээний ажилтан, химийн цехийн ээлжийн дарга, засварын мастер, инженер, лабораторийн эрхлэгч, түлш тосны техникч, сорьц бэлтгэгч, механик цехийн дарга, металл судлалын лабораторийн эрхлэгч, инженер, гагнуурын инженер, түлш дамжуулах цехийн ээлжийн дарга, цехийн инженер, хүнд механизмын механик, төмөр замын инженер, төмөр замын дохиолол холбооны монтёр, замчин, щитийн аппаратын монтёр, дэд станцын ашиглалтын мастер, ДКВР, КЕ, КВТС болон тэдгээртэй адилтгах байнгын ажиллагаатай уурын зуухны машинч, туслах машинч, засварчин, цахилгаанчин, механикч, ашиглалтын инженер, засварчин, ээлжийн монтёр, засварын монтёр, гагнуурчин, төвийн эрчим хүчний системийн химийн албаны хэсгийн инженер, лабораторийн инженер, түлш, тос, хаягдал усны технологич, инженер, шинжилгээ, хэмжих хэсгийн техникч, лаборант, засварчин, цахилгаан шугам сүлжээний шуурхай үйлчилгээний ээлжийн инженер, техникч, монтёр, тусгай тоноглолын машины монтёр-жолооч, өндөр үелзлэлийн холбооны монтёр, техникч, инженер.

**2.** Уул уурхайн үйлдвэрлэлийн цооног өрөмдөгч, түүний туслах, цооног цэнэглэх, баяжуулах фабрикийн тоног төхөөрөмж, технологийн зориулалттай хүнд даацын авто машины засварын слесарь, цахилгааны слесарь, төвлөрсөн засварын газар уурхай, баяжуулах фабрикийн тоног төхөөрөмжийн засварчин, реагент бэлтгэгч, тэсрэх материал зөөгч, маркшейдерийн ажилчин,

насосны машинч, хийн үлээгүүр, вакуум насосны машинч, нүүрс баяжуулах аппаратчин, ачих төхөөрөмжийн операторчин, уурхайн технологийн зориулалттай хүнд даацын авто машины жолооч, засварчин, соронзон ангилагч, хөөсрүүлэх машинч, өтгөрүүлэгч, хөвүүлэгч, шүүлтүүрчин, баяжмал жигнүүрч, бигнүүрч, хатаагч, хаягдал юүлэгч, туналга тохируулагч, бункерчин, тэжээгчийн моторчин, столчин, терроникийн машинч, конвейерийн машинч, нүүрс, хүдэр, чулуу, шавар ялгагч, бутлагч, тээрэмдэгч, шигшигч, эрдэс баяжмал хольц савлагч, ачигч, дээж авагч, биетийг ачигч, чанар шалгагч, драгийн ажилчин, ангилан ашиглалтын (прампирбороор) ахлах машинч, туслах машинч, алт угаагч, алт хайлагч, хайгуулын өрмийн мастер, өрөмдөгч, төмөрлөг эдлэлийг никель, хром, зэс, алт, мөнгөөр өнгөлөгч, цайр чанагч, цайрдагч, хими цэвэрлэгээний машинч, уул уурхайн үйлдвэрлэлд зориулагдсан энгийн тэсрэх бодис ачигч, тун тохируулагч, тэсрэх бодис зөөдөг тусгай тоноглогдсон машины жолооч, үйлдвэрлэлийн агааржуулалт, агаар солилт (калорифель)-ын системийн үйлчилгээ, засварын слесарь, баяжуулах фабрикийн хаягдлын аж ахуйн ажилчид, тэсэлгээ, цахилгаан, ус шүүрүүлэхийн слесарь, мастер, механикч, цахилгааны хэсгийн дарга, инженер, ахлах мастер, зам овоолго, хөрс хуулалт, хүдэр гаргалт, тээвэр технологийн дамжлага, тэсэлгээний хэсгийн мастер, маркшейдер, геологич, механикч, цахилгаанчин, замын хэсгийн дарга, тоног төхөөрөмжийн засварын мастер, хэсгийн дарга, хүнд даацын машин, (белаз, краз, самосваль, эксковатор, бульдозер, трактор, гүүрэн ба шөргөн, хийн, дугуйт, гинжит кран, автогрейдр), машинч, жолооч, сорьц бутлагч, уусмалчин, өрмийн засварчин, үйлдвэрийн бохирын слесарь, цэвэрлэгч, төмөр огтлогч, цахилгаан цэгийн гагнуурчин, эмульсээр шавлагч, чулуу, металиар гоёл чимэглэл хийгч, гагнуурчин, шингэн шил чанагч, цахилгаан тэргэнцэрийн жолооч, модельшик, токорьчин, фрезерчин, КИПА слесарь, тоног төхөөрөмжийн засварчин, төмөр ачигч, буулгагч, аккумуляторчин, технологийн дамжлагын механикч, хэсгийн дарга, ээлжийн мастер, инженер.

**3.** Төмөр замын зүтгүүрийн зааварлагч машинч, машинч, туслах машинч, ахлах жижүүр-зааварлагч машинч, ээлжийн жижүүр-машинч, зүтгүүрийн реостат тохируулгын инженер, засварын мастер, хүлээн авагч, мотовоз, дрезины машинч, жолооч, түүний туслах, вагон засварын машин засварчин, механикч, вагон, зүтгүүрийн хос дугуй зорогч (бүрэлдэхүүнээс салгахгүйгээр), үйлдвэрлэлийн суваг талбайн цэвэрлэгч, хөдлөх бүрэлдэхүүний засварын слесарь, засварчин, техник үйлчилгээний вагон үзэгч-засварчин, нарийн хэмжүүрийн техникч, галт тэрэгний найруулагч, найруулагчийн туслах (вагон холбогч), галт тэрэгний диспетчер, ахлах диспетчер, ивүүрчин, сэлгээний ажлын диспетчер, ачаа-вагон хүлээлцэгч (Шарын гол, Шивээ овоо, Хөтөл, Айраг, Бор-Өндөр, Өргөн өртөөний), суудлын вагон завод ба депогийн засварын үед явах анги, цахилгаан тоноглол, засварлагч зам чигжигч, металл хатаагч, мотор ороогч, модельник, цутгуурчин, түлшний нярав, тос ялгагч, ангигүй өртөөний жижүүр, лакотарын засварчин, механизмын слесарь, инженер, инженер механик, машинч, инженер операторч, туслах машинч, цахилгааны инженер, чиг татагч, моторт тавцант вагон, хопер, дозатор, думкар, цас, зам цэвэрлэгч болон хүнд машин механизмын слесарь, цахилгаанчин, механикч, операторч, дизельчин, зам, гүүр тавигч, хуулагч, сумчин, сумт краны машинч, нүүрс ачигч, буулгагч, тракторчин, бульдозорчин, зүтгүүр, вагоныг хатуу, шингэн түлшээр зэхэгч, галын хор цэнэглэгч, хими цэвэрлэгээний машинч, иргэний агаарын тээврийн нисэх онгоцны үйлчлэгч (календарийн жилд 500-с доошгүй цагийн нислэг хийсэн), онгоцонд засвар үйлчилгээ хийдэг инженер, техникч, цахилгаан хийн гагнуурчин, вагон засварын механикч, сэв шалгагч, будагчин, пийшинчин, дизельчин, эксковаторчин, вагон засварын газрын халуун төмрийн дархан.

**4.** Мод бэлтгэлийн мастер, мод унагаагч, мөчирлөгч, цагаалагч, булхайдагч, хөрөөчин, ойчин, тракторчин, ачигч (эрүүт), уулын хүнд машин механизмын слесарь, механикч, технологийн зориулалттай хүнд даацын машины жолооч.

**5.** Антен мачтын антенчин, техникч, радио, телевизийн болон явуулын станц, сансрын станцын холбооны хэт өндөр үелзлэлд ажилладаг болон RGS, PCAQ станц түүнтэй адилтгах станцын лакаторын инженер, техникч, хот хоорондын шугамын монтер, тугалган бүрээстэй кабель, шугамын монтажчин, засварчин, техникч, кабельчин, холбооны зай тэжээлийн аккумуляторчин, аккумуляторын техникч, улс, хот хоорондын телефон станцын залгагч (2000 оноос өмнө ажиллагсад хамаарна), дизель генератороор ажилладаг радиорелейний дундын

станцын цахилгаан тэжээлийн монтёр, технологийн зориулалттай дохиоллын байгууламж дээр ажилладаг шугамын механикч-монтёр.

**6.** Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ болон дамжуулах станцуудын 6 киловольтоос дээш хүчдэлийн агаарын ба кабель шугам, дэд станцын ашиглалт, хэмжүүрийн инженер мастер, засварын монтёр, монтажчин, засварчин, цахилгаан ба хийн гагнуурчин, аккумулятор цэнэглэгч, засагч, пластик цутгагч, өргөх зөөх болон тусгай тоноглолын дэд станцын засварчин, өндөр үелзлэлийн холбооны инженер, монтёр.

**7.** Цементийн үйлдвэрлэлийн дутангийн насосны жинхэнэ, туслах машинч, клинкерийн агуулахын кранч, жолооч, уулын цехийн шохойн чулууны карьерийн өрөмдөгч, тэсэлгээчин, түүний туслах, хүнд даацын машины жолооч, клинкерийн агуулах ба уулын цехийн бульдозерчин, эксковаторчин, компрессорчин, цахилгаанчин, цехүүдийн дарга, мастер, инженер, бохир ба сантехник, салхивчны слесарь, тоног төхөөрөмжийн засварчин, цемент ачигч.

**8.** Эрдэс хөвөнгийн үйлдвэрлэлийн хатаах байгууламжийн операторч, тоног төхөөрөмжийн тохируулагч, тоног төхөөрөмжийн засварчин, цахилгаанчин, сантехникийн засварчин, операторч, жижүүрийн үйлчлэгч, аспирацын засварчин, шнур чихэгч.

**9.** Керамик эдлэлийн үйлдвэрлэлийн зуух доторлогч.

**10.** Карьерийн аж ахуйн эксковаторчин, бульдозерчин, тракторчин, тоног төхөөрөмжийн засварчин, цахилгаанчин, халуун төмрийн дархан, авто ба гүүрэн кранчин, бутлагч, тэсэлгээчин, технологийн хүнд даацын машины жолооч, лаборант, цахилгаан ба хийн гагнуурчин, өрмийн машинч, туслах.

**11.** Барилгын болон бетон, төмөр хийцийн нийгэм ахуйн барилгын үйлдвэрлэл, бетон эдлэлийн өнгөлгөөчин, төмөр бетон хийц хэвлэгч, шарагч, флюсын гагнуурчин, тоног төхөөрөмжийн засварчин, цахилгаанчин, дохиочид, арматурчин, зуурмагийн туузан дамжлагын операторч, хэв тоологч, тунагч, зуурагч, бетоны хольц бэлтгэгч, бетончин, мастер, цемент ачиж буулгагч краны машинч, цахилгаан ба хийн гагнуурчин, арматурын цэгийн гагнуурчин, сунган таслагч, тулган гагнагч, арматур тайрагч, сантехникийн бохирын слесарь, компрессорчин, сантехникийн засварчин, технологийн зориулалттай хүнд даацын машины жолооч, бетон угсрагч, машинаар төмөр зүсэгч, токарчин, фрезерчин, бойлерын жижүүр, тээрмийн машинч, зуурах машины операторчин, хэв бэлтгэж, блок зүсэх дамжлагын операторчин, тоног төхөөрөмжийн засварчин, цахилгаанчин, гүүрэн кранчин, оосорлогч, ээлжийн мастер, яндан хоолой угсрагч, дулаалагч, тусгаарлагч, хүнд механизмын засварчин, усны насосчин, шаварчин, будагчин, газар ухагч, засварын даамал, талбайн инженер, бульдозерчин, битум, мазут, хар тос чанагч, цацагч, автогудропарч, шилэн хөвөн авагч, тавигч.

**12.** Тоосго үйлдвэрлэлийн тоосго хэвлэх, өрөх, дамжлагын шавар зуурагч машины оператор, шатаалгын тэрэг тослогч, эксковатор, бутлуур, шнекрийн болон туузан дамжлагын операторч, хольц бэлтгэгч тоноглолын засварчин, цахилгаанчин, сантехникийн слесарь, үнс, нурам зөөгч, тоосго хатаах зуухны галч, хатаагуурын камер цэвэрлэгч, уурын зуухны галч, хэвлэсэн тоосго хатаагуурын камер цэвэрлэгч, уурын зуухны галч, хэвлэсэн тоосго тэргэнцэрт өрөгч, тэргэнцэртэй тоосгыг хатаах камерт оруулагч, татагч, гүүрэн кранчин, оосорлогч, бульдозерчин, эксковаторчин, покарийн засварчин, аккумулятор цэнэглэгч, хүнд механизмын засварчин, цахилгаан ба хийн гагнуурчин, тоосго ялгагч, лаборант, дугуй зуух, хэвлэх, шороон хэсгийн мастер.

**13.** Азот, хүчилтөрөгчийн станцын машинч, генераторчин, компрессорчин, цэнэглэгч, тоног төхөөрөмжийн засварчин, слесарь, аппаратчин, тээх ажиллах төхөөрөмжийн машинч, мастер.

**14.** Гурил, тэжээл үйлдвэрлэлийн тээрэмдэх машины гол ирлэгч.

**15.** Хөдөө аж ахуйн малын их бага эмч, санитарч, тракторчин, комбайнч (1995 оноос өмнөх хугацаа хамаарна).

**16.** Бохир усны төвлөрсөн системийн насосны станцын машинч, туслах машинч, агааржуулах станц, идэвхт лаг, түүхий үлдэцийн машинч, сараалж, элс, тос баригч, тунгаагч, биошүүлтүүр, аэротанк, лаг, талбай, хлорт байгууламжийн операторч, цахилгааны монтёр, тоног төхөөрөмж, КИП автоматик, хлор узель, бойлерийн слесарь, бохир усны шугам хоолой цэвэрлэх байгууламжийн техникч, слесарь, лаг зөөврийн машинч-жолооч, лаг ачиж түрэх эксковаторчин, бульдозерчин, механик технологийн инженер, цахилгаанчин, насосны



оператор, машинт заалны машинч, шүүх талбайн оператор, цэвэрлэх байгууламжийн цахилгаан ба хийн гагнуурчин, хими бактериологийн лабораторийн бактериологч, химич, лаборант, дээж авагч, шил сав угаагч, тоног төхөөрөмжийн засварчин, КУ-гийн машинч, КИП автоматикийн инженер, цахилгааны инженер, тоног төхөөрөмжийн инженер, хувцас угаагч.

**17.** Зоос гоёлын зүйлийн үйлдвэрлэлийн резин ба воскон хэвчин, гинж нэхэгч, алт мөнгөн эдлэлийн дархан.

**18.** Ноос, ноолуур, хивсний боловсруулах үйлдвэрлэлийн ялгагч, зөөгч, сэгсрэх машин баригч, хялгас ялгах цехийн машин баригч, угаах машин баригч, будаг найруулагч, нүүрсжүүлэх машинч, хатаах машинч, баглах машинч, тоног төхөөрөмжийн засварчин, токарчин, фрезерчин, цахилгаан ба хийн гагнуурчин, сантехникийн засварчин, хими цехийн инженер, лаборант, будаг хэмжигч, будагчин, цардагч, мотор ороогч.

**19.** Арьс шир, үслэг эдлэлийн үйлдвэрлэлийн арьс хүлээн авч чанарын хамгаалалт хийгч, оруулагч, арьс чийглэгч, зүлгэгч, талхигч, сунгагч, захлагч, зөөлрүүлэгч, тэнийлгэгч, арьс хэмжигч, баглаа боодлын ажилчин, тоног төхөөрөмжийн засварчин, зуухны машинч, цахилгаанчин, цахилгаан ба хийн гагнуурчин, сантехникийн слесарь, бойлерын жижүүр.

**20.** Эсгий, эсгий гутал үйлдвэрлэлийн самнах, сэмлэх, даахь урах, хаягдал цэвэрлэх, сэгсрэх машин баригч, засварчин, эсгий гутал хатаагч, эсгий гутал чангаруулагч, хүчлийн машинч, резин холио бэлтгэгч, резинээр гутал уллагч, ноос цэвэрлэх, холих, баглаа задлах машинч.

**21.** Гутлын үйлдвэрлэлийн ул, өсгийн үрлэг, фрезер хийгч, компрессорчин, мастер.

**22.** Мебель үйлдвэрлэлийн багаж ирлээчин, пүржиний суурь машинч, компрессорчин, толь цайрдагч, хуулгын хавтангийн операторчин, мод боловсруулах суурь машинч, мод бутлахын суурь машинч.

**23.** Чулуу үйлдвэрлэлийн чулуу хөрөөдөгч, хагалагч, өнгөлөгч, бутлагч, гараар засагч.

**24.** Зам гүүрийн барилга, засвар, арчлалтын асфальт-бетончин, арматурчин, компоессорчин, токарьчин, фрезерчин, гагнуурчин, технологийн зориулалттай машин механизмын жолооч, засварчин.

**25.** Тогтмол байнгын ажиллагаатай аммиакын хөргөгч, байгууламжийн машинч, моторчин, слесарь, компрессорчин, цахилгаанчин, техникч.

**26.** Химийн урвалж, реактивийн төвлөрсөн агуулахын нярав, ачигч-буулгагч, насосны станцын машинч, засварчин, цахилгаанчин, гагнуурчин.

**27.** Байгалийн голомтот халдварт өвчнийг эсэргүүцэн судлах төвийн ажлын түргэн тусламжийн жолооч, хээрийн шинжилгээний жолооч, авто лабораторийн жолооч, автын механикч, тарваган тахлын голомт хяналтын бага эмч, сувилагч, ерөнхий эмч, тасгийн эрхлэгч, агнан бэлтгэгч, халдвар судлалын их эмч, халдвартын механик, тусгаарлах байрны тарилгын сувилагч, амьтан маллагч, тоног төхөөрөмжийн засварчин, цахилгаанчин.

**28.** Биохими, бактериологи, иммунологи, гистологи, мөөгөнцөр, нян, вирус, шимэгч, ийлдэс, халдвар, шавьж судлал, эсийн өсгөвөр, хор, хөгц, ургамлын хими, эм судлал, эмийн хими, технологи, клиник лаборатори, эмгэг анатомын лабораторийн хүн мал их бага эмч, химич, биохимич, бактерлогич, халдвар судлагч, гистологич, иммунологич, шимэгч, судлагч, автоклавчин, гидробиологич, микробиологич, гинелогич (малын), амьтан маллагч, эрдэм шинжилгээний жинхэнэ, туслах ажилтан, био бэлдмэлчин, лаборант, шил сав угаагч, ариутгагч.

**29.** Тархи, мэдрэл, дүрх, хэвлийн хөндий, ясны мэс заслыг байнга хийдэг их, бага эмч, сувилагч, асрагч, нойрсуулагч ба сэхээн амьдруулахын, патоанатомийн задлан шинжилгээний болон цус бэлтгэх үйлдвэрлэлийн их, бага эмч, сувилагч, асрагч, цогцос ажиллагч.

**30.** Хурц, архаг халдварт өвчин болон сэтгэцийн эмгэгтэй өвчтөнийг эмчлэн сувилах ажлыг байнга гардан гүйцэтгэдэг их, бага эмч, зөвлөх эмч, сувилагч, асрагч, ариутгагч, цагаан хэрэглэл угаагч, бохирын слесарь, рашаан сувилалын шавар тавигч, шавар бэлтгэгч.

**31.** Өдөр бүр тогтмол химийн материалаар гардан ажиллаж ус, хөрс, агаар, ургамал, амьтны гаралтай бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүн, химийн ба барилгын материал, эрдэс, бордоо, эм, нүүрс, занар, нефть бүтээгдэхүүн, палентиологи, геохими, криминалистикийн шинжээч, металл судлагч, үнэт металл сорьц тавигч<sup>1</sup>, хортон шавьжид шинжилгээ хийдэг эрдэм шинжилгээний тэргүүлэх, ахлах, жинхэнэ, туслах ажилтан, химич, биохимич, эм найруулагч, инженер, металлургич, технологич, минералогич, энтомологич, физиологич, шинжээч, лаборант, техникч, бэлдмэлчин, ариутгагч, шил сав угаагч.

**32.** Хүдрийн бус ашигт малтмал, баяжуулалт, палентологийн шинжилгээний гүйцэтгэгч,

инженер, чулуу зүсэгч, гүйцэтгэгч болон техник лаборант, дархан, шил үлээлгийн мастер, фото зургийн мастер, аргачлал, стандарт, хяналтын лаборант, агааржуулалт, электроник, автоматикийн инженер, слесарь, тоног төхөөрөмжийн засварчин, лаборант.

**33.** Улсын үйлдвэрийн зорчигч тээврийн автобус, цахилгаан тээврийн жолооч, кондуктор, дугуй нөхөгч, аккумуляторчин, цахилгаан ба хийн тугалган гагнуурчин, кузов засварчин, нимгэн төмөрчин, хүйтэн гагнуурчин, цахилгаанчин, мотор ороогч, хортой шингэн ба нефть бүтээгдэхүүнээр машины эд ангийг угааж засдаг агрегатын засварчин, будагчин, урсгал засварын засварчид, засвар үйлдвэрлэлийн токарьчин, фрезерчин, өнгөлгөөчин, цахилгаан ба хийн гагнуурчин.

**34.** Эм биобэлдмэлийн үйлдвэрлэлийн эм боогч, савлагч, ургамал нунтаглагч, гарнульчин, эм найруулагч, технологич, амбегийн машинч, пропон-компрессорчин, вакцин ийлдэс, тэжээлт орчин бэлтгэгч, шинжээч, хүн малын эмч, биохимич, эмзүйч, химич, биологич, лаборант, техникч, аппаратчин, шил угаагч, амьтан маллагч.

**35.** Шил шаазангийн үйлдвэрийн өрөмдөгч, тэсэлгээчин, ээлжийн мастер, компрессорчин, чулуун материал татагч, бутлагч, тээрэмдэгч, жор найруулагч, бэлдмэл шахагч, гипсэн хэв хийгч, загвар зохион бүтээгч, хэвлэгч, цутгагч, будаг бэхжүүлэх ба шатаах зуухны операторчин, паалангийн хээ тавигч (зураач), тоног төхөөрөмжийн засварчин, цахилгаанчин, мастер, технологич, цехийн дарга, химич, лаборант.

**36.** Цэргийн зориулалттай танк, хуягт, их буу, хүнд механизмын засварчин, лак будагчин, мотор туршигч, цахилгаан хөдөлгүүр ороогч, шатахуун тоноглолын засварчин, цахилгаан ба хийн гагнуурчин, тахир гол өнгөлөгч, клапан билүүдэгч, металл хучигч, лакатор засагч.

**37.** Гэрэлтүүлэг чимэглэлийн үйлдвэрийн гагнуурчин, цахилгаанчин, органик шилчин, вакуумчин, будагчин, төмөрчин.

**38.** НАА, орон сууц тохижилт үйлчилгээ, бохир усны слесарь, гагнуурчин, нийтийн бие засах газрын үйлчлэгч, будагчин, засварчин, үл хамаарах системтэй дулаан хувиарлах төвийн машинч, зам талбайн үйлчлэгч, ургамлын хортон шавьж устгагч, хор найруулагч, ургамал хамгааллын мэргэжилтэн, хүлэмжийн хор цацагч, хог ачигч, хог түрдэг бульдозерчин, эксковаторчин, засварчин, хог асгах цэгийн диспетчер, нохой, муурын анчин.

**39.** Шохой үйлдвэрлэлийн тэсэлгээчин, түүний туслах, цүнхчин, тэсрэх бодисын нярав, өрөмдөгч, шохой шатаагч, бутлагч, шохой гаргагч, үнс нурам зөөгч, нүүрс, шохой шатах, тослох материалын нярав, хүнд даацын машины жолооч, хянагч, эмч, сувилагч, асрагч.

**40.** Аммиакын хөргөх байгууламжийн машинч, моторчин, слесарь, компрессорчин, цахилгаанчин, техникч, инженер, махны үйлдвэрийн бохирын слесарь, техникч, инженер, ариутгалын группын мастер, ариутгагч, устгагч, мал нядлагч, толгой, шийр зумлагч.